

БАТЛАВ.
ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Г.МАНЛАЙЖАВ

БАТЛАВ.
“xxxxxxxx” ХХК-ИЙН ДАРГА/
ЗАХИРАЛ
НННННННННН

ИОНЖУУЛАГЧ ЦАЦРАГ ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛД
ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА, БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ГЭРЭЭ

20... оны ... сарын ...-ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Дозиметрийн тохируулга, баталгаажуулалтын лабораторийн ахлах мэргэжилтэн Ц.Билгүүн /цаашид “Үйлчлэгч тал” гэх/, нөгөө талаас “xxxxxxxx” ХХК /цаашид “Үйлчлүүлэгч тал” гэх/-ийн дарга/захирал нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ дараах зүйлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр ионжуулагч цацраг хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, баталгаажуулалт хийхтэй холбоотой болон Талуудын хооронд гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Талууд Цөмийн энергийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний, итгэмжлэлийн тухай хууль, Цацрагийн аюулгүйн норм, Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дүрэм болон цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, шалгалт тохируулга, баталгаажуулалттай холбоотой үндэсний болон олон улсын дүрэм журам, стандартыг мөрдлөг болгоно.

ХОЁР. ҮЙЛЧЛЭГЧ ТАЛЫН ЭРХ ,ҮҮРЭГ

2.1. Үйлчлэгч тал нь шалгалт тохируулга, баталгаажуулалтад хамруулахаар ирүүлсэн хэмжих хэрэгслийг Үйлчлүүлэгч талаас хүлээн авах, хүлээлгэн өгөхөд бүрэн бүтэн байдлыг шалгаж, протокол хөтөлнө.

2.2. Хүлээн авсан хэмжих хэрэгслийг ажлын 10 хоногт багтаан батлагдсан, хүчин төгөлдөр стандарт, арга аргачлалын дагуу шалган, баталгаажуулж гэрчилгээг олгоно.

2.3. Хүлээн авсан хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгөх хүртэл хариуцна.

ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТАЛЫН ЭРХ ,ҮҮРЭГ

3.1. Шалгалт тохируулга, баталгаажуулалтад хамруулах ионжуулагч цацраг хэмжих хэрэгслийн мэдээллийг “Хавсралт-1”-д заасны дагуу тодорхойлж, хэмжих хэрэгслийн гарын авлага, цэнэглэгч, батарейн хамт Үйлчлэгч талд хүргүүлнэ.

3.2. Жил бүр, графикт хугацаанд хэмжих хэрэгслийг шалгалт тохируулга, баталгаажуулалтад заавал хамруулна.

3.3. Тээвэрлэлтийн явцад хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

3.4. Энэхүү гэрээний 4.1-т заасан хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын төлбөрийг хугацаанд төлж, төлбөр төлсөн баримтыг Үйлчлэгч талд хүргүүлнэ.

3.5. Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт, ашиглалттай холбоотой Үйлчлэгч талын тавьсан шаардлага, нөхцөлийг биелүүлж ажиллана.

3.6. Гэрээнд заасан хэмжих хэрэгслийн тоо, нэр төрөлд өөрчлөлт орсон, шинээр авсан, ашиглалтаас гарсан тохиолдолд энэ талаар Үйлчлэгч талд албан бичгээр тухай бүр мэдэгдэнэ.

ДӨРӨВ. ТӨЛБӨР

4.1. Үйлчлүүлэгч тал нь энэ гэрээний 1.2-т холбогдох ионжуулагч цацраг хэмжих хэрэгслийг Үйлчлэгч талд хүлээлгэн өгснөөс хойш ажлын 5 хоногт багтаан Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар тушаалаар батлагдсан “Хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-ний дагуу хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын төлбөрийг 100 хувь төлнө.

4.2. Төлбөрийн хэмжээг шалгалт тохируулга, баталгаажуулалтад хамруулж буй хэмжих хэрэгсэл бүрээр Цөмийн энергийн комиссын санхүүгийн тэмдэгтэй нэхэмжлэх маягтаар нэхэмжилсэн байна.

4.3. Төлбөрийг Төрийн сан /Цөмийн энергийн комисс/-гийн 100900008037 тоот дансанд тушаана.

ТАВ. МЭДЭГДЭЛ

5.1. Үйлчлэгч тал шалгалт тохируулга, баталгаажуулалтад тэнцээгүй ионжуулагч цацраг хэмжих хэрэгслийг цаашид ашиглах боломжгүй талаар Үйлчлүүлэгч талд мэдэгдэх хуудас хүргүүлнэ.

5.2. Энэхүү гэрээний 5.1-д заасан мэдэгдэх хуудсыг хүлээн авсан тохиолдолд тухайн багажийг үйл ажиллагаандаа ашиглахыг хориглоно.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, баталгаажсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Гэрээг 20... оны дугаар сарын -ны өдрөөс 20... оны дугаар сарын ... -ний өдөр хүртэл 3 жилийн хугацаатай байгуулав.

Гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд гэрээний хувь тус бүр адил хүчинтэй.

6.3. Энэхүү гэрээний 6.2-т заасан хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө Талууд гэрээг цуцлах тухай санал гараагүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар дахин нэг удаа сунгасанд тооцно.

6.4 Талууд харилцан тохиролцож, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь хоёр талын эрх бүхий төлөөлөгчид зөвхөн бичгээр үйлдэж, гарын үсэг зурж, тамга дарсан тохиолдолд хүчин төгөлдөр байна. Нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

6.5. Үйлчлэгч тал жил бүр гэрээний гүйцэтгэлтэй холбоотой судалгаа гаргах бөгөөд хэрэв Үйлчлүүлэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үйлчлэгч тал:

Үйлчлүүлэгч тал:

ЦЭК-ЫН АЖЛЫН АЛБЫГ ТӨЛӨӨЛЖ,

“xxxxxxxxxx” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ

ЦӨМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА

ДАРГА/ЗАХИРАЛ

...../Э.НЯМДАВАА/

...../НННННННННН/

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

ЦАЦРАГИЙН ХЯНАЛТЫН АЖИЛТАН

...../П.НОМИН-ЭРДЭНЭ/

..... /НННННННННН/

ДОЗИМЕТРИЙН ТОХИРУУЛГА,
БАТАЛГААЖУУЛАЛТЫН
ЛАБОРАТОРИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

..... /Ц.БИЛГҮҮН/

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
20 дугаар хороо, Үйлдвэрчийн 2 тоот.
Утас: 51-267148

Хаяг:
Утас:

Шалгалт тохируулга, баталгаажуулалтад хамруулах
хэмжих хэрэгслийн мэдээлэл

д/д	Хэмжих хэрэгслийн нэр	Серийн дугаар	Хэмжих цацрагийн төрөл	Хэмжих нэгж	Үйлдвэрлэсэн улс, он
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					

oooOOOooo